НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 08 өдөр Дугаар А/145 Улаанбаатар хот

Нийслэлийн ИТХ-ын ээлжит бус I
хуралдааныг товлон зарлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, 46.6 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.1 дэх заалт, Хуралдааны дэгийн 4 дүгээр зүйлийн 4.2, 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус I хуралдааныг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 10.00 цагаас хуралдуулахаар товыг тогтоож, дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:

1.1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай

1.2.Дэд төвүүдийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл батлах тухай

1.3.Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Хотын стандарт)

1.4.Нийтийн зориулалттай орон сууцыг балансаас баланст шилжүүлэх тухай

1.5.Барилга байгууламж акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах тухай

1.6.Төрийн шагналд тодорхойлж уламжлах тухай

1.7.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийг байгуулах тухай

1.8.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороо байгуулах, түүний чиглэл, бүрэлдэхүүнийг батлах тухай

1.9.Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

1.10.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай

1.11.Тогтоол хүчингүй болгох тухай (Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 269 дүгээр тогтоол, 2009 оны 30 дугаар тогтоол, 2014 оны 92, 167 дугаар тогтоол)

2.Энэлжит бус I хуралдааны бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (Б.Батбямба)-нд үүрэг болгосугай.

ДАРГА А.БАЯР